



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2012 оны 02 сарын 15 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 219 дүгээр тогтоолоор 7  
батлагдсан журмыг шинэчлэн батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, 34.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалт, шалгалтанд орохыг хүссэн өргөдөл, үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтний анкет, гэрчилгээ, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийн аттестатчилалд хамрагдахыг хүссэн өргөдлийн маягтыг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 219 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Журамд заасан үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, гэрчилгээ олгох, аттестатчилах, хүчингүй болгохыг Хорооны дарга/Д.Баярсайхан/-д зөвшөөрсүгэй.

4. Батлагдсан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд сурталчилахыг Тамгын газар/Д.Нямцэрэн/-д тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулах хорооны  
2012 оны 02 дугаар сарын 15-ны  
36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛЛАХ МЭРГЭЖИЛТЭНД  
АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ЯВУУЛАХ ЭРХ ОЛГОХ,  
АТТЕСТАТЧИЛАХ ТУХАЙ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1 Энэ журмаар үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагад ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, аттестатчилахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэн” /цаашид “мэргэжилтэн” гэх/ гэж үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын /цаашид “мэргэжлийн байгууллага” гэх/ үндсэн чиг үүргийг гүйцэтгэх ажил эрхэлдэг, Хорооноос үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан этгээдийг хэлнэ.

1.3. “Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх” гэж мэргэжлийн байгууллагыг төлөөлж үнэт цаасны зах зээлд оролцохоор Хорооноос авсан эрхийг хэлнэ.

1.4 Хороо дараах чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгоно.

1.4.1. Брокер, дилерийн чиглэлээр,

1.4.2. Хөрөнгө оруулалтын чиглэлээр,

1.4.3. Үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн чиглэлээр,

1.5. Мэргэжилтэн нь эрхлэх ажил үйлчилгээний төрлөөс хамааран дор дурдсан эрхийг авсан байна:

1.5.1. Брокер, дилерийн ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтэн нь энэхүү журмын 1.4.1-д заасан;

1.5.2. Мэргэжлийн байгууллагын гүйцэтгэх удирдлага, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер, хөрөнгө оруулалтын сангийн менежер, санхүүгийн шинжээч зэрэг чиглэлээр ажил үйлчилгээ явуулах мэргэжилтэн нь энэхүү журмын 1.4.2-т заасан;

1.5.3 Санхүүгийн чадварын зэрэглэл тогтоох, үнэт цаасны арилжааны төлбөр, тооцооны, үнэт цаасны хадгаламжийн, үнэт цаасны кастодианы, үнэт цаасны арилжаа зохион байгуулах зэрэг чиглэлээр ажил, үйлчилгээ явуулах мэргэжилтэн нь энэхүү журмын 1.4.3-т заасан.

**Хоёр. Мэргэшлийн зөвлөл**

2.1. Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах сургалт /цаашид “сургалт” гэх/ зохион байгуулах, түүнд хяналт тавих, шалгалтыг зохион байгуулах чиг үүргийг орон тооны бус Мэргэшлийн зөвлөл хэрэгжүүлнэ.

2.2. Мэргэшлийн зөвлөл нь нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн байх бөгөөд тэдгээрийг Хорооны дарга томилно.

2.3. Мэргэшлийн зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнд Хорооны ажлын албаны болон мэргэжлийн байгууллагын холбоо, их, дээд сургуульд үнэт цаасны чиглэлээр хичээл заадаг

эрдмийн зэрэг, цолтой багш, судлаачдын төлөөлөл орж болох бөгөөд зөвлөлийн дарга нь Хорооны үнэт цаасны зах зээл хариуцсан орон тооны гишүүн байна.

2.4 . Мэргэшлийн зөвлөл дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

- 2.4.1. Энэхүү журмын 1.4-д заасан эрх олгох шалгалт авах;
- 2.4.2. Энэ журамд заасан сургалт тус бүрээр үндсэн хөтөлбөр боловсруулах;
- 2.4.3. Сургалт зохион байгуулагчаас явуулж буй сургалтын чанарыг хянах;
- 2.4.4. Шалгалтын тест боловсруулах;
- 2.4.5. Шалгалтын тест боловсруулахад шаардлагатай тестийн сан бүрдүүлэх;
- 2.4.6. Шалгалтын хуваарь боловсруулж батлах;
- 2.4.7. Сургалт зохион байгуулагчаас үндсэн хөтөлбөр дээр үндэслэн боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянах, батлах;
- 2.4.8. Шалгалтын асуулт, тестийг бусдаар бөглүүлэх, хуулах зэрэг үйлдэл хийсэн оролцогчдыг протоколд тэмдэглэж, шалгалтаас хасах;
- 2.4.9. Шалгалтын тест болон асуултын нууцыг чанд хадгалах;
- 2.4.10. Мэргэшлийн зөвлөлийн үйл ажиллагаанд өөрийн биеэр оролцох;
- 2.4.11. Шалгалтын дүнг Хороонд танилцуулах, батлуулах.

2.5. Мэргэшлийн зөвлөл нь шийдвэрийг дийлэнх олонхийн саналаар гаргана.

2.6. Мэргэшлийн зөвлөлийн дарга орон нутагт ажиллах зөвлөлийн гишүүдийг тухай бүр томилж болно.

2.7. Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга дараах эрх, үүрэгтэй:

- 2.7.1. Мэргэшлийн зөвлөлийн хуралдааны тэмдэглэл хөтлөж, зөвлөлийн дарга, гишүүдээр батлуулах;
- 2.7.2. Шалгалтад хамрагдахаар өргөдөл гаргасан этгээдийн бичиг, баримтыг энэхүү журамд нийцүүлэн хүлээн авч бүртгэх;
- 2.7.3. Шалгалтад орохоор өргөдөл гаргасан этгээдэд Хорооны цахим хуудас, бусад арга хэрэгсэлээр шалгалт, сургалтын товыг хүргэх;
- 2.7.4. Шалгалтын зохион байгуулалтын ажлыг хариуцах;
- 2.7.5. Шалгалт болон Мэргэшлийн зөвлөлийн хуралдаантай холбоотой тэмдэглэл хөтөлж, баримт бичгийг цэгцлэн Хорооны архивт шилжүүлэх;

2.8. Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга нь Үнэт цаасны газрын сургалт хариуцсан ажилтан байх бөгөөд Мэргэшлийн зөвлөлийн хуралдаанд саналын эрх эдлэхгүй.

### **Гурав. Шалгалт, шалгалтын тест бэлтгэх, олшруулах, нууцыг хадгалах**

3.1. Мэдээллийн санд бүрдүүлсэн тестүүдээс шалгалтын асуултыг боловсруулна.

3.2. Шалгалтын тестийг шалгалтын өмнөх өдөр Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон гишүүд боловсруулна.

3.3. Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон 2-оос доошгүй гишүүн шалгалтын тестийг хувилж, хувилбар тус бүрээр тоолж дугтуйлан битүүмжилнэ.

3.4. Шалгалтын тест олшруулах байранд Мэргэшлийн зөвлөлийн даргын томилсон гишүүдээс өөр хүнийг зөвшөөрөлгүйгээр нэвтрүүлэхийг хориглоно.

3.5. Мэргэшлийн зөвлөлийн ба ажлын хэсгийн гишүүд шалгалт эхлэхээс 30 минутын өмнө шалгалтын байранд ирж шалгалт авах бэлтгэлийг хангасан байна.

3.6. Тестийг битүүмжилсэн байдлаар шалгалт авах танхимд хүргэж шалгалтад оролцогчдоор магадлуулж уг танхимд задлана.

3.7. Гадаадын иргэд шалгалтад оролцоходоо орчуулагчтай орж болох бөгөөд орчуулагч нь үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх аваагүй байх шаардлагатай.

### **Дөрөв. Сургалт зохион байгуулах**

4.1. Хороо сургалт зохион байгуулах эрхийг сургалт зохион байгуулах шаардлага хангасан их, дээд сургууль, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагад гэрээгээр шилжүүлснээс бусад тохиолдолд сургалтыг Хороо зохион байгуулна.

4.2. Хорооноос сургалт зохион байгуулах эрх авсан байгууллага /цаашид “сургалт зохион байгуулагч” гэх/ нь дараах чиглэлээр сургалтыг зохион байгуулна:

4.2.1 Үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох анхан шатны сургалт;

4.2.2. Үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалт:

4.2.2.1. брокер, дилерийн;

4.2.2.2. хөрөнгө оруулалтын;

4.2.2.3. үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн;

4.2.3 Мэргэжилтнийг аттестатчилах үргэлжилсэн багц цагийн сургалт.

4.3. Сургалт зохион байгуулагч нь дээр дурдсан сургалт тус бүрээр хөтөлбөр боловсруулан Мэргэшлийн зөвлөлөөр батлуулна.

4.4. Сургалт зохион байгуулагч нь Мэргэшлийн зөвлөлийн гаргасан шалгалтын хуваарийн дагуу энэ журмын 4.2.2, 4.2.3-т заасан сургалтын жилийн төлөвлөгөө батлан олон нийтэд мэдээллэнэ.

4.5. Энэ журмын 4.2.1-ээс бусад сургалтыг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

4.6. Энэ журмын 4.2.1-ээс бусад сургалтанд хамрагдах иргэдийн тоог Мэргэшлийн зөвлөл тухай бүр тогтооно.

4.7. Сургалтад оролцох этгээд нь дараах шаардлагыг хангасан байна:

4.7.1. Эдийн засаг, санхүү, эрх зүйн чиглэлээр бакалавраас доошгүй зэрэгтэй;

4.7.2. Энэ журмын 4.7.1-т заасан шаардлагыг хангаагүй боловч бусад мэргэжлээр бакалаврын зэрэг авсан этгээд нь Хорооны шаардлага хангасан үнэт цаасны зах зээлийн талаар мэдлэг олгох анхан шатны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна;

4.7.3. Сүүлийн 3 жилийн хугацаанд мэргэжлийн алдаанаас болж дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний улмаас тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон, мэргэжлийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлж байгаагүй;

4.7.4. Зохих төлбөр төлсөн.

4.8. Сургалтад суух этгээд нь 2 дугаар хавсралтын “Маягт-1”-ын дагуу өргөдөл, “Маягт-2”-ын дагуу анкетыг бөглөж, 4.7.1- 4.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримтын хамт бүрдүүлж бүртгүүлнэ.

4.9. Энэхүү журмын 4.2.2.1-д заасан чиглэлээр 45-аас доошгүй, 4.2.2.2 болон 4.2.2.3-д заасан чиглэлээр эрх олгох сургалт тус тус нийт 70-аас доошгүй, 4.2.3-д заасан чиглэлээр эрх нь хүчинтэй байх хугацаанд 45-аас доошгүй нэгж цаг байх бөгөөд нэг нэгж цаг нь 45 минуттай тэнцэхүйц үнэт цаасны зах зээлтэй холбоотой эдийн засаг, санхүү, нягтлан бодох бүртгэл, хөрөнгө оруулалт, эрсдлийн удирдлага, эрх зүйн зохицуулалтын гүнзгийрүүлсэн сэдэв, агуулгатай байна.

4.10. Сургалтыг техник, тоног төхөөрөмжийн шаардлага хангасан, тараах материал сургалтанд оролцогч бүрт хүртээмжтэй байхаар зохион байгуулна.

4.11. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ явуулах эрхтэй эсхүл сургалтад суухгүйгээр шалгалтад орох боломжтой гэж үзсэн этгээд нь сургалтад хамрагдахгүйгээр шалгалтад орох өргөдөл гаргаж болно. Өргөдлийн үндсэн дээр сургалтад суух эсэх асуудлын талаар Мэргэшлийн зөвлөл хэлэлцэж шийдвэр гаргана.

4.12. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтад 4.11-д заасан этгээд нь тэнцээгүй тохиолдолд сургалтад бүрэн сууж шалгалтад хамрагдах эрхтэй болно.

4.13. Сургалтын төлбөрийн хэмжээг Хорооны дарга тогтооно.

**Тав. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ  
явуулах эрх олгох шалгалт авах, эрх олгох**

5.1. Энэхүү журмын 4.2.2-д заасан сургалт тус бүрд 80 хувиас доошгүй цагийн сургалтыг хангасан этгээдээс үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх олгох шалгалт авна.

5.2. Шалгалтыг тест болон ярилцлага гэсэн 2 үе шаттай авна. Тестийн болон ярилцлагын агуулга, тестийн асуултын тоо, үргэлжлэх хугацааг Мэргэшлийн зөвлөл тогтооно.

5.3. Шалгалтын хариултыг Мэргэшлийн зөвлөл дүгнэнэ.

5.4. Шалгалтын цаг дууссаны дараагаар хариултын хуудсыг шалгуулагчдын өмнө тусгай төхөрөөмжөөр уншуулан жагсаалтаар дүнг гаргаж Мэргэшлийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

5.5. Жагсаалтаар гарсан дүнг өөрчлөх буюу засахыг хориглоно.

5.6. Мэргэшлийн зөвлөл нь шалгалт өгсөн этгээдийг өөрийн тест бөглөсөн байдалтай танилцах боломжоор хангаж болно.

5.7. Тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулсан этгээд нь дараагийн шатны шалгалт буюу ярилцлагад орно. Ярилцлага 5 асуулттай байх бөгөөд түүнээс 60-аас дээш хувийг үнэн зөв хариулсан этгээдийг Мэргэшлийн зөвлөл шалгалтад тэнцсэнд тооцно.

5.8. Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг чиглэл тус бүрээр 3 жилийн хугацаатайгаар Хороо олгоно.

5.9. Хөрөнгө оруулалтын чиглэлээр эрх авсан этгээд нь брокер, дилэрийн эрхийг мөн адил эдлэнэ.

5.10. Тестийн шалгалтанд тэнцээгүй иргэдээс дахин шалгалт нэг удаа авах бөгөөд Мэргэшлийн зөвлөл дахин шалгалтын товыг эхний шалгалт авах өдөр тогтооно. Уг дахин шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй тохиолдолд дараагийн дахин шалгалтад хамрагдах боломжгүй.

5.10 Дахин шалгалтад хамрагдах тухай өргөдлөө дахин шалгалт болохоос ажлын 3 хоногийн өмнө сургалт зохион байгуулагчид гаргана. Өргөдөл гаргаагүй тохиолдолд дахин шалгалтад хамруулахгүй.

5.11 Дахин шалгалтын тестийн асуултын 70 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулан ярилцлагад тэнцсэн мэргэжилтэнд энэ журмын 5.8-д заасны дагуу мөн адил эрх олгоно.

5.12 Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан этгээдэд энэ журмын 2 дугаар хавсралтын “Маягт-3”-ын дагуу гэрчилгээ олгоно.

5.13 Шалгалтын төлбөрийн хэмжээг Хорооны дарга тогтооно.

### **Зургаа. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхтэй мэргэжилтэнг аттестатчилах**

6.1. Мэргэжилтэнг аттестатчилах үргэлжилсэн багц цагийн сургалтын хүрээнд Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх нь хүчинтэй байгаа мэргэжилтэн нь уг эрхийг хүчинтэй байх хугацаанд жил бүр зохион байгуулагдах аттестатчилах багц цагийн сургалтанд 80-аас доошгүй хувьд хамрагдах үүрэгтэй.

6.2. Мэргэжилтэнг аттестатчилах үргэлжилсэн багц цагийн сургалтад сууж, зохих багц цагийг хангасан мэргэжилтэн нь сургалт зохион байгуулагчид хандаж аттестатчилалд хамрагдах өргөдлийг 2 дугаар хавсралтын “Маягт-4”-ын дагуу эрх нь дуусгавар болохоос 1 сарын өмнө гаргана.

6.3. Аттестатчилалд хамрагдах өргөдөл гаргасан мэргэжилтнүүдийн жагсаалтыг сургалт зохион байгуулагч нь нэгдсэн журмаар Мэргэшлийн зөвлөлийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

6.4. Шалгалтыг тест болон ярилцлага гэсэн 2 үе шаттай авах бөгөөд тестийн асуултын тоо, шалгалтын үргэлжлэх хугацааг Мэргэшлийн зөвлөл тогтооно.

6.5. Тестийн асуултын 60 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулсан этгээд нь дараагийн шатны шалгалт буюу ярилцлагад орно. Ярилцлага 5 асуулттай байх бөгөөд түүнээс 60-аас дээш хувийг үнэн зөв хариулсан мэргэжилтэнг Мэргэшлийн зөвлөл шалгалтад тэнцсэнд тооцно

6.6. Хороо Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг чиглэл тус бүрээр дахин 4 жилээр, 2 дахь удаа аттестатчилах шалгалт өгч тэнцсэн тохиолдолд 6 жилээр сунгах, 3 дахь удаа шалгалт өгч тэнцсэн тохиолдолд хугацаагүй эрх олгох бөгөөд энэ заалт журам батлагдсан өдрөөс хэрэгжиж эхэлнэ.

6.7. Шалгалтад тэнцээгүй мэргэжилтнээс дахин шалгалт нэг удаа авна.

6.8. Тестийн шалгалтанд тэнцээгүй иргэдээс дахин шалгалт нэг удаа авах бөгөөд Мэргэшлийн зөвлөл дахин шалгалтын товыг эхний шалгалт авах өдөр тогтооно. Уг дахин шалгалтад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хамрагдаагүй тохиолдолд дараагийн дахин шалгалтад хамрагдах боломжгүй.

6.9. Дахин шалгалтанд хамрагдах тухай өргөдлөө дахин шалгалт болохоос ажлын 3 хоногийн өмнө сургалт зохион байгуулагчид гаргана. Өргөдөл гаргаагүй тохиолдолд дахин шалгалтанд хамруулахгүй.

6.10. Дахин шалгалтын тестийн асуултын 70 буюу түүнээс дээш хувийг үнэн зөв хариулан ярилцлагад тэнцсэн мэргэжилтэнд энэ журмын 6.6-д заасны дагуу мөн адил эрх олгоно.

6.11. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрх авсан этгээдэд энэ журмын 2 дугаар хавсралтын “Маягт-5”-ын дагуу гэрчилгээ олгоно.

6.12. Мэргэшлийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн аттестатчилах шалгалтад тэнцээгүй эсхүл 6.1-д заасан шаардлагыг хангаагүйгээс шалгалтанд хамрагдаагүй мэргэжилтний эрхийг Хороо хүчингүй болгох шийдвэр гаргана.

6.13. Аттестатчилах шалгалтад тэнцээгүй, 6.1-д заасан шаардлагыг хангаагүй мэргэжилтэн нь үнэт цаасны зах зээлд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох сургалтад суусны дараагаар шалгалт өгч энэ журмын 5.7 заасан шаардлагыг хангасан тохиолдолд Хороо эрхийг 3 жилийн хугацатайгаар шинээр олгоно.

6.14. Хороо дараах тохиолдолд мэргэжилтнийг хугацаанаас нь өмнө дахин аттестатчилалд орохыг шаардаж болно:

6.14.1. Түүний харъяалагддаг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн байгууллага нь дахин шалгалтад оруулах үндэслэл бүхий хүсэлт гаргасан;

6.14.2. Мэргэжилтний үйл ажиллагаатай холбогдуулж харилцагчдаас үндэслэл бүхий гомдол гаргаж мэргэжилтний буруутай нь тогтоогдсон;

6.14.3. Хорооноос томилогдсон хянан шалгалтын ажлын хэсэг мэргэжилтний мэдлэг, ур чадвар, ёс зүйн хэм хэмжээний шаардлага хангахгүй байгаа гэсэн дүгнэлт гаргасан.

6.14.4. Арилжаа эрхлэгчдийн холбооны ёс зүйн хорооноос дахин аттестатчилах шаардлагатай гэх үндэслэл бүхий дүгнэлт гаргасан.

#### **Долоо. Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

7.1. Дараах тохиолдолд Хороо үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг 2 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:

7.1.1. Иргэн, хуулийн этгээдээс өргөдөл гаргасны дагуу шалгалт хийж, түр түдгэлзүүлэх үндэслэл байгааг тогтоосон;

7.1.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн.

7.2. Дараах тохиолдолд Хороо үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ явуулах эрхийг хүчингүй болгоно:

7.2.1. Хүндэтгэх шалтгаангүйгээр мэргэжилтэн аттестатчилах үргэлжилсэн багц цагийн сургалтад хамрагдаагүй, зохих багц цагийг хангаагүй;

7.2.2. Үнэт цаасны зах зээлийн хууль тогтоомжийг удаа дараа болон ноцтойгоор зөрчсөн нь тогтоогдсон;

7.2.3. Мэргэжилтэн нь Хороо, хөрөнгийн бирж, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллагуудад өөрийн талаар худал мэдээлэл өгсөн;

7.2.4. Эрхийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаагүй;

7.2.5. Мэргэжилтэн гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон;

7.2.6. Арилжаа эрхлэгчдийн холбоо Холбооны ёс зүйн хорооноос шалгагдан мэргэжилтний ёс зүйн алдаа гаргасан тухай үндэслэл бүхий дүгнэлт гарсан;

7.3. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан Хорооны цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэлээр нийтэд мэдээлнэ.

7.4. Мэргэжилтэн энэ журмын 7.1 болон 7.2-т заасан асуудлаар Хорооноос гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл Хяналтын зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

7.5. Сургалт болон шалгалтын явцад энэхүү журмаар зохицуулагдаагүй харилцаа үүссэн тохиолдолд тухайн асуудлыг Мэргэшлийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

-- ооОоо --



ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХ ЭРХ ОЛГОХ СУРГАЛТ, ШАЛГАЛТАД ОРУУЛАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....  
Хаана: Санхүүгийн зохицуулах хороо  
Засгийн газрын IV байр  
Бага тойруу -6  
Улаанбаатар -210646  
Монгол улс

Хэнээс: ..... овогтой  
.....

Миний бие үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрх олгох сургалт, шалгалтад оролцохоор хүсэлт гаргаж байна.

Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад оролцохоор бүрдүүлж хүргүүлсэн бичиг баримтуудыг үнэн зөв бүрдүүлсэн болно. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг миний бие хүлээнэ.

Өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянан шалгаж, үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад оролцуулна уу.

Миний бие цаашид “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль” болон холбогдох хууль тогтоомж, журам зааврыг мөрдлөг болгож, мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж байх болно.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

/...../  
/гарын үсэг/

/...../  
/овог, нэр/

Маягт-2

**ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД АЖИЛЛАХ  
МЭРГЭЖИЛТНИЙ АНКЕТ**

Иргэний үнэмлэхийн дугаар			
Регистрийн дугаар			
Овог нэр			Төрсөн он/сар/өдөр
<b>ОДООГИЙН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>			
Ажиллаж буй албан байгууллагын нэр			
Ямар алба/хэлтэс болох Албан тушаал			
Ажлын болон гар утас			
Факс			
Е-мэйл хаяг			
<b>ӨМНӨ НЬ ЭРХЭЛЖ БАЙСАН АЖЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ</b>			
Ажиллаж байсан албан байгууллагын нэр			
Ямар ажил эрхэлж байсан			
Ажилласан хугацаа	....оноос....он хүртэл	....оноос....он хүртэл	....оноос....он хүртэл
<b>БОЛОВСРОЛЫН ТУХАЙ</b>			
Төгссөн сургуулийн нэр			
Эзэмшсэн мэргэжил			
Эрдмийн зэрэг цол			
Төгссөн он			
<b>УРАГ ТӨРЛИЙН БАЙДАЛ</b>			
Овог нэр	Таны юу болох	Төрсөн он	Одоо эрхэлж байгаа ажил/ сургууль

Дээрх мэдээллийг үнэн зөв бичсэн ..... /гарын үсэг/  
201 оны ... сарын ... өдөр



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ГЭРЧИЛГЭЭ

ДУГААР ....

..... оны ..... сарын ..... өдөр

Монгол улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 34.1.3 болон 34.1.5 дахь заалт, “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ын шаардлагыг хангасан тул:

.....овогтой.....-нд  
/РД:...../ Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх олгох шалгалтанд амжилттай дүн үзүүлж тэнцсэн тул  
..... үйл ажиллагааны чиглэлээр 20... оны ..... дүгээр сарын ....-ий өдрөөс 20... оны ... дүгээр сарын ... –ий өдрийг хүртэл Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг 3 жилийн хугацаатайгаар олгов.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Маягт 4

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛД МЭРГЭЖЛИЙН АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХ ЭРХИЙН АТТЕСТАТЧИЛАЛД ХАМРАГДАХЫГ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо : .....

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо

Засгийн газрын IV байр

Бага тойруу -6

Улаанбаатар -210646

Монгол улс

Хэнээс: ..... овогтой

Регистрийн дугаар: .....

Миний бие үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд эрхийн  
аттестатчилалын

сургалт, шалгалтад оролцохоор хүсэлт гаргаж байна.

Үнэт цаасны зах зээлд ажил үйлчилгээ эрхлэх эрх олгох сургалт, шалгалтад  
оролцохоор бүрдүүлж хүргүүлсэн бичиг баримтуудад  
өөрчлөлт ороогүй.

өөрчлөлт орсон тул үнэн зөв бүрдүүлж хавсаргав. Бүрдүүлсэн бичиг баримтад аливаа  
худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг миний бие хүлээнэ.

Иймд өргөдөл, холбогдох бичиг баримтыг хянаж, үнэт цаасны зах зээлд  
мэргэжлийн

ажил үйлчилгээ эрхлэх эрхийн аттестатчилалын сургалт, шалгалтад оролцуулна уу.

Миний бие Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад хууль  
тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллах ба Санхүүгийн зохицуулах хорооноос  
тавьсан шаардлагуудыг бүрэн биелүүлж ажиллах болно.

ОДОО АЖИЛЛАЖ БУЙ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛ

/...../...../...../

БАЙНГА ОРШИН СУУХ ХАЯГ, УТАС

/...../

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ: /.....//.....//гарын үсэг/ /овог, нэр /



МОНГОЛ УЛСЫН  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО  
ГЭРЧИЛГЭЭ

ДУГААР ....

..... оны ..... сарын ..... өдөр

Монгол улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 34.1.3 болон 34.1.5 дахь заалт, “Үнэт цаасны зах зээлд ажиллах мэргэжилтэнд ажил, үйлчилгээ явуулах эрх олгох, аттестатчилах тухай журам”-ын шаардлагыг хангасан тул:

.....овогтой..... /РД:...../

Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах аттестатчилах шалгалтанд амжилттай дүн үзүүлж тэнцсэн тул

..... үйл ажиллагааны чиглэлээр 20... оны ..... дүгээр сарын ....-ий өдрөөс 20... оны ... дүгээр сарын ... –ий өдрийг хүртэл Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрхийг ... жилийн хугацаатайгаар сунгав.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

